



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 469

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 6 нэрийн, нийт 266,528,000.00 (хоёр зуун жаран зургаан сая таван зуун хорин найман мянга) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид (Завхан аймаг, Алдархаан сум) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батмэнд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг Завхан аймаг, Алдархаан сумын Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлж бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002169

22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
469 дугаар тогтоолын хавсралт

Завхан аймгийн Алдархаан сумын Засаг даргын тамгын газарт
бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хамгаалалтын зурвас- Улиас 3 настай	ш	2400	23,000.00	55,200,000.00
2	Хамгаалалтын зурвас- Хайлаас 3 настай	ш	454	23,000.00	10,442,000.00
3	Нарны зайгаар ажилладаг, цахилгаан өргүүртэй худаг, барилгатай	ш	1	47,756,000.00	47,756,000.00
4	25 тн ёмкость	ш	1	18,000,000.00	18,000,000.00
5	Усалгааны систем	м	1500	10,700.00	16,050,000.00
6	Хамгаалалтын хашаа	м	2290	52,000.00	119,080,000.00
Дүн					266,528,000.00
					(хоёр зуун жаран зургаан сая таван зуун хорин найман мянга) төгрөг